



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ**

2024 оны 04 сарын 05 өдөр

Дугаар А/218

Булган сум


**439 дүгээр хаалттай хорих ангид техник тоног  
төхөөрөмж авахад дэмжлэг үзүүлэх тухай**

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.2, 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Аймгийн Засаг даргын 2020-2024 оны “Шинэ хөгжлийн зам” үйл ажиллагааны хөтөлбөрт өөрчлөлт оруулах тухай” аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны хуралдааны XIII/02 дугаар тогтоолын 4.3.7, Хууль зүй, дотоод хэргийн сайдаас Булган аймгийн Засаг даргатай 2024 онд хамтран ажиллах гэрээний 3 дугаар зүйлийн 3.1.9.1, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалаар батлагдсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 2 дугаар зүйлийн 2.1.4 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын харьяа 439 дүгээр хаалттай хорих ангийн албан хаагчдын ажиллах нөхцөлийг сайжруулахад 12,889,580 (арван хоёр сая найман зуун наян есөн мянга таван зуун наяд) төгрөгийн техник, тоног төхөөрөмжийн дэмжлэг үзүүлсүгэй.

2. Шаардагдах хөрөнгийг аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс зарцуулахыг аймгийн Засаг даргын Тамгын газар (Д.Алтаншагай)-т зөвшөөрсүгэй.

3. Хөрөнгийг зориулалтын дагуу зарцуулсан зардлын тооцоо, гүйцэтгэлийг гаргаж аймгийн Засаг даргын Тамгын газарт тайлагнахыг 439 дүгээр хаалттай хорих анги (хурандаа Н.Батгэрэл)-д, хяналт тавьж ажиллахыг Хууль, эрх зүйн хэлтэс (Б.Одхүү)-т үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА  Б.АРИУН-ЭРДЭНЭ